



2022



ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ
ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН ЭДЛЭЛИЙН
АРИЛЖАА ЭРХЛЭГЧДИЙН 2022 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАНГИЙН
НЭГТГЭЛИЙН

ТАНИЛЦУУЛГА

ХУРААНГУЙ

Бүртгэл, зөвшөөрлийн чиглэлд: Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 47 хуулийн этгээд, 465 иргэнийг бүртгэлжүүлээд байна. Тайлант он буюу 2022 оны байдлаар дээрх тусгай зөвшөөрөл бүхий арилжаа эрхлэгчид нь үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа, үнэт металл, үнэт чулууны арилжаа, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа гэсэн 3 төрлийн үйл ажиллагааг эрхэлж байна.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн тайлагнал сайжрав. Санхүүгийн зохицуулах хороо нь зайны хяналт, шалгалтын хүрээнд тайлант онд давхардсан тоогоор 240 ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээд, 1,903 ҮМҮЧЭТХЭАЭ иргэнээс холбогдох тайлан, мэдээг хүлээн авч, хянан баталгаажуулж, нэгтгэлд хамруулсан.

Монголбанк тайлант онд 22.9 тонн алт худалдан авав. Монголбанк нь 2022 оны байдлаар 22.9 тонн алтыг 3.3 их наяд төгрөгөөр худалдан авсан бөгөөд үүний 8.9 тонн алтыг 392 иргэнээс, 13.9 тонн алтыг 656 хуулийн этгээдээс тус тус худалдан авсан байна.

(Эх сурвалж: Монголбанкны үнэт металлын худалдан авалтын мэдээ)

Үнэт металл, үнэт чулууны арилжааны тойм: Тайлант онд энэ төрлийн арилжаа эрхлэгчдийн хувьд 8.5 тонн алтыг худалдан авч, 8.3 тонн алтыг худалдан борлуулсан байна.

Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжааны тойм: Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч нь тайлант онд 14.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийжээ.

Санхүүгийн тайлангийн үзүүлэлт: Тайлант онд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн нийт орлого 72.3 тэрбум төгрөгт хүрч, 14.1 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд газар дээрх үзлэг, хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв. Тайлант онд нэр бүхий 99 иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд газар дээрх хэсэгчилсэн болон иж бүрэн хяналт, шалгалт, үзлэгийг хийж гүйцэтгэн холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

Зөвлөмж боловсруулав. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох хүрээнд нэр бүхий 16 төрийн байгууллагад салбарын зохицуулалтыг сайжруулах зөвлөмжийг хүргүүлсэн.

ОРШИЛ

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн салбар нь Монгол Улсын нийгэм, эдийн засагт томоохон нөлөө үзүүлдэг дундын зохицуулалттай салбаруудын нэг юм.

Санхүүгийн зохицуулах хороо нь 2020 оноос эхлэн үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тэдгээрийн үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлснээс хойш өнөөг хүртэлх хугацаанд нийт 47 хуулийн этгээд, 465 иргэнд дээрх төрлийн тусгай зөвшөөрлийг олгож, бүртгэлжүүлснээс гадна Улсын бүртгэлд холбогдох өөрчлөлтийг бүртгүүлээгүй 230 хуулийн этгээдийн энэ төрлийн үйл ажиллагааг хүчингүй болгосон.

Энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэгчид нь хяналт, зохицуулалтад хамрагдсанаар салбарын нийгэм, эдийн засагт оруулж буй хувь нэмрийг тодорхойлж, эдийн засгийн ач холбогдол бүхий тоон мэдээлэл, үзүүлэлтүүдийг гарган, түүнд үндэслэсэн бодлогын арга хэмжээг тодорхойлох, олон нийтэд дээрх төрлийн үйл ажиллагааг сурталчлан таниулах, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зэрэг давуу талууд бий болсон.

Жил ирэх тусам зохицуулалттай этгээдүүдийн тоо нэмэгдэхийн зэрэгцээ ҮМҮЧЭТХЭА-ны бизнесийн чиг хандлага өөрчлөгдөж, үүнийг даган төрийн хяналт зохицуулалтын арга хэлбэр ч мөн адил хувьсан өөрчлөгдөж байна. Дэлхийн улс орнуудын тухайд алтны нийлүүлэлтийн сүлжээг ил тод болгох, гарал үүслийг тодорхойлох, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлд анхаарч ажиллахын сацуу технологийн шийдлүүдийг хяналт зохицуулалтад ашиглаж эхэлсэн байна.

Санхүүгийн зохицуулах хороо нь олон улсын жишиг, туршлагаудтай хөл нийлүүлж, энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжих, нэмүү өртөг шингээсэн эцсийн бүтээгдэхүүнийг олон улсад экспортлох, мөн улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх, мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах зэрэг чиглэлд холбогдох судалгааг хийж, түүнд үндэслэсэн бодлогын арга хэмжээг авч хэрэгжүүлэх, эрх зүйн таатай орчинг бүрдүүлэхэд анхаарч ажиллаж байна.

Хороо нь олон нийтэд салбарын мэдээллийг тухай бүр хүргэх зорилгоор үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн тайлангийн товч танилцуулгыг 6 дахь удаагаа бэлтгэн хүргэж байна.



Товчилсон нэрийн тайлбар

Хороо	Санхүүгийн зохицуулах хороо
ҮМҮЧЭТХЭАЭ	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч
ҮМҮЧЭТХЭА	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХНХ	Хувь нийлүүлсэн хөрөнгө
ТЗ	Тусгай зөвшөөрөл

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. ҮМҮЧЭТХЭАЭ-ийн салбарт хэрэгжиж буй журмууд.....	2
Хүснэгт 2. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэдийн насны ангилал.....	7
Хүснэгт 3. Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч иргэдийн насны ангилал.....	7
Хүснэгт 4. Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэдийн насны ангилал.....	7
Хүснэгт 5. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн 2022 оны санхүүгийн тайлан (мянган төгрөг).....	10
Хүснэгт 6. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн санхүүгийн тайлангийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөг).....	11
Хүснэгт 7. ҮМҮЧЭТХЭАЭ-дийн орлогын бүтэц (мянган төгрөг).....	13
Хүснэгт 8. ҮМҮЧЭТХЭАЭ-дийн зардлын бүтэц (мянган төгрөг).....	14

Дүрслэлийн жагсаалт

Дүрслэл 1. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгосон байдал (өссөн дүнгээр).....	4
Дүрслэл 2. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд (өссөн дүнгээр).....	4
Дүрслэл 3. Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч иргэд (өссөн дүнгээр).....	4
Дүрслэл 4. Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд (өссөн дүнгээр).....	4
Дүрслэл 5. МУ-д үйл ажиллагаа эрхэлж буй ҮМҮЧЭТХЭАЭ-ийн тархалтын мэдээлэл.(иргэн, хуулийн этгээд).....	6
Дүрслэл 6. Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ҮМҮЧЭТХЭАЭ-ийн мэдээлэл.....	6

Дүрслэл 7. Монголбанканд алт тушаасан харилцагчид (хувиар).....	8
Дүрслэл 8. Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ (тонн).....	8
Дүрслэл 9. Алтны борлуулалтын мэдээ (мянган төгрөг).....	9
Дүрслэл 10. Мөнгөний борлуулалтын мэдээ (мянган төгрөг).....	9
Дүрслэл 11. Санхүүгийн тайлангийн бүтэц.....	11
Дүрслэл 12. Хөрөнгийн бүтэц	12
Дүрслэл 13. Өр төлбөрийн бүтэц	12
Дүрслэл 14. Эздийн өмчийн бүтэц	12
Дүрслэл 15. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт (мянган төгрөг).....	12
Дүрслэл 16. Орлогын бүтэц	13
Дүрслэл 17. Зардлын бүтэц	14

Графикийн жагсаалт

График 1. ХНХ-ийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлт (2020-2022 он, мянган төгрөг).....	6
---	---


БАТЛАГДСАН ЖУРМУУД

Хүснэгт 1. Салбарт хэрэгжиж буй журмууд


Д/Д	Журмын нэр	Баталсан огноо	Тогтоолын дугаар
1	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олголт, бүртгэлийн журам	2020.03.25	150
2	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчээс төвлөрүүлэх зохицуулалт үйлчилгээний хөлсний хэмжээг тогтоосон журам	2020.03.25	151
3	Тохиромжтой этгээдийг тодорхойлох журам	2020.04.08	179
4	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаанд зайны болон газар дээрх хяналт, шалгалт хийх журам	2020.04.08	182
5	Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн мэргэжлийн холбоонд тавигдах шаардлагыг тодорхойлох журам	2020.12.23	1048
6	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам	2023.01.13	22

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН
ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ

ИРГЭН




ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
ТОО



ОРОН
НУТАГ **94**

УЛААНБААТАР
ХОТ **371**




Бүтээгдэхүүний нэр төрөл (дотоод)

Цалин цагаан 999	Замбуулингоёл	Таван нүдэн
Дарьганга гоёл	Мөнгөнзээбад	Байгал
Мөнгөн талст	Дорнын цас	Дансран
Гоёл хийц	Эрдэнийн дөл	Эрдэм гоёл
Тайж гоёл	Мөнгөн гоёо	Нүүдэлчний соёл
Мөнгөн самнаа	Арт-Эрдэнэ	Тэнгэрийн угалз
Батгоёл хийц	Тулга гоёл	Есүйтэй гоёл
Бүрэнсүх	Эрдэнийн гоёл	Заант
	Гоёлтрейд	
Алтанмөнгөн хонх		


Бүтээгдэхүүний нэр төрөл (гадаад)

Pandora гоёл чимэлэл	EPL Mongolia Yakutian Diamond
Manoe E Даймонд	ROLEX Цаг
Diamond house Даймонд	Damiani Даймонд
Mikoto Сувд	ARIS Даймонд
Su-ao Үнэт эдлэл	Divine Jewellery
Christian Bauer Mongolia	


**ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ҮНЭТ МЕТАЛЛ, ҮНЭТ ЧУЛУУНЫ, ЭСХҮЛ ТЭДГЭЭРЭЭР ХИЙСЭН
ЭДЛЭЛИЙН АРИЛЖАА ЭРХЛЭГЧ**




Дүрслэл 1. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдэд тусгай зөвшөөрөл олгосон байдал (өссөн дүнгээр)



Дүрслэл 2. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд (өссөн дүнгээр)




Дүрслэл 3. Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч иргэд (өссөн дүнгээр)



Дүрслэл 4. Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд (өссөн дүнгээр)

ШИЙДВЭРЛЭСЭН ХҮСЭЛТҮҮД

Тусгай зөвшөөрөл



Зөвшөөрөл



ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагааны төрөл




Тайлант хугацааны байдлаар үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 26 хуулийн этгээд, 255 иргэн, үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч 5 хуулийн этгээд, 140 иргэн, үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 16 хуулийн этгээд, 70 иргэн бүртгэгдсэн байна.



ҮМҮЧЭТХЭАЭ-ийн тархалтын мэдээлэл

Хорооноос үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 47 хуулийн этгээд, 465 иргэн нь Монгол Улсын 11 аймаг, Улаанбаатар хотын 6 дүүрэгт үйл ажиллагаа эрхэлж байна. Үүнээс, 94 иргэн, 1 хуулийн этгээд орон нутагт үйл ажиллагаа эрхэлж байгаа бол 371 иргэн, 46 хуулийн этгээд нь Улаанбаатар хотын Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул дүүргүүдэд төвлөрсөн байна.



Дүрслэл 5. МУ-д үйл ажиллагаа эрхэлж буй ҮМҮЧЭТХЭАЭ-ийн тархалтын мэдээлэл. (иргэн, хуулийн этгээд)



Дүрслэл 6. Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж буй ҮМҮЧЭТХЭАЭ-ийн мэдээлэл.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчийн бүтэц, бүрэлдэхүүн






Тайлант онд ҮМҮЧЭТХЭАЭ 47 хуулийн этгээд нь 75 хувьцаа эзэмшигчийн 9,404,419.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн бөгөөд хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.5 хувиар өссөн байна.



График 1. ХНХ-ийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлт (2020-2022 он, мянган төгрөг)

СТАТИСТИК МЭДЭЭЛЭЛ

Хувьцаа эзэмшигчийн тоо



2020.IV

2021.IV

2022.IV

ҮМҮЧЭТХЭАЭ-ийн хүйсийн харьцаа

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд



63%

37%

Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч иргэд



64%

36%

Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэд



33%

67%

ҮМҮЧЭТХЭАЭ-ийн насны бүтэц

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн 0.9 хувийг 18-24 насныхан, 14.4 хувийг 25-34 насныхан, 35 хувийг 35-45 насныхан, 33 хувийг 46-55 насныхан, 16.7 хувийг 55-аас дээш насныхан тус тус эзэлж байна.

Эрхэлж буй үйл ажиллагааны чиглэлээр насны ангилалыг дэлгэрэнгүй байдлаар Хүснэгт 1, 2, 3-т харуулав.

Насны ангилал	Иргэдийн тоо
18-24	1
25-34	10
35-45	30
46-55	25
55+	4

Хүснэгт 2. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэдийн насны ангилал.

Насны ангилал	Иргэдийн тоо
18-24	2
25-34	25
35-45	40
46-55	50
55+	23

Хүснэгт 3. Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч иргэдийн насны ангилал.


Насны ангилал	Иргэдийн тоо
18-24	1
25-34	32
35-45	93
46-55	78
55+	51

Хүснэгт 4. Үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч иргэдийн насны ангилал.


Үнэт металлын худалдан авалтын мэдээ

Тайлант он буюу 2022 оны жилийн эцсийн байдлаар Монголбанканд нийт 1,048 харилцагч алт тушааснаас 63 хувь буюу 656 нь аж ахуйн нэгж, 37 хувь буюу 392 нь иргэд байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад Монголбанканд алт тушаах иргэд, аж ахуйн нэгжийн тоо 84 буюу 8.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Эх сурвалж: Монголбанкны алтны худалдан авалтын мэдээ



Дүрслэл 7. Монголбанканд алт тушаасан харилцагчид (хувиар)



Дүрслэл 8. Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ (тонн)

Монголбанкны худалдан авсан алтны хэмжээ

Монголбанк 2022 оны жилийн эцсийн байдлаар 22.9 тонн алтыг 3.3 их наяд төгрөгөөр худалдан авсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт худалдаж авсан алтны хэмжээ 2.1 тонн буюу 10 хувиар өссөн байна.

Эх сурвалж: Монголбанкны алтны худалдан авалтын мэдээ

БОРЛУУЛАЛТЫН ТОЙМ

Үнэт металл, үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжааны мэдээ

Тайлант онд 14.7 тэрбум төгрөгийн үнэт эдлэлийг худалдан борлуулсан бөгөөд өмнөх оны мөн үеэс 3.9 тэрбум төгрөг буюу 36.1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.





АЛТ

ХУДАЛДСАН

670,518,154.9
8.3 ТН МЯНГАН ₮

ХУДАЛДАН АВСАН

699,391,516.9
МЯНГАН ₮

8.5 ТН

Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь тайлант хугацаанд 8.5 тонн алтыг 699,391,516.9 мянган төгрөгөөр худалдан авч, 8.3 тонн алтыг 670,518,154.9 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал худалдан авсан алтны хэмжээ 115,780,015.7 мянган төгрөгөөр буюу 20 хувиар өссөн бол худалдсан алтны хэмжээ 23,683,113.0 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар буурсан байна.

МӨНГӨ

ХУДАЛДСАН

284,162.6
92.8 КГ МЯНГАН ₮

ХУДАЛДАН АВСАН

707,357.3
МЯНГАН ₮

182.1 КГ



Тайлант хугацаанд үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь нийт 182.1 кг мөнгийг 707,357.3 мянган төгрөгөөр худалдан авч, 92.8 кг мөнгийг 284,162.6 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдаж авсан мөнгөний хэмжээ 2.5 дахин буюу 426,509.1 мянган төгрөгөөр, худалдсан мөнгөний хэмжээ 1.2 дахин буюу 40,836.1 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ҮЗҮҮЛЭЛТ	2021 он	Нийт хөрөнгөд эзлэх хувь	2022 он	Нийт хөрөнгөд эзлэх хувь
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	3,458,896.4	10%	7,371,108.1	13%
Дансны авлага	4,097,677.1	12%	4,367,349.7	8%
Татвар, НДШ – ийн авлага	476,174.6	1%	610,968.2	1%
Бусад авлага	1,520,278.5	4%	1,085,702.4	2%
Бараа материал	12,116,862.5	36%	24,303,528.1	42%
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	2,279,351.3	7%	3,787,761.3	7%
Бусад эргэлтийн хөрөнгө	242,308.6	1%	247,604.9	0%
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	1,331,425.1	4%	2,260,613.4	4%
Эргэлтийн хөрөнгийн дүн	25,522,974.1	75%	44,034,636.1	76%
Үндсэн хөрөнгө	7,566,144.7	22%	12,258,005.2	21%
Биет бус хөрөнгө	293,093.4	1%	295,908.9	1%
Урт хугацаат хөрөнгө оруулалт	54,574.1	0%	407,374.1	1%
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	574,432.7	2%	574,432.7	1%
Хойшлогдсон татварын хөрөнгө	1,070.8	0%	37,100.1	0%
Бусад эргэлтийн бус хөрөнгө			434,057.0	1%
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	8,489,315.7	25%	14,006,878.0	24%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	34,012,289.8	100%	58,041,514.1	100%
Дансны өглөг	11,357,306.4	33%	18,222,769.5	31%
Цалингийн өглөг	81,678.7	0%	142,416.2	0%
Татварын өр	613,556.6	2%	2,075,235.0	4%
НДШ - ийн өглөг	82,529.8	0%	169,255.5	0%
Богино хугацаат зээл	2,308,099.2	7%	2,650,319.6	5%
Ногдол ашгийн өглөг			750,000.0	1%
Хүүний өглөг	882,244.8	3%	792,619.4	1%
Урьдчилж орсон орлого	4,463,269.7	13%	5,418,477.7	9%
Нөөц /өр төлбөр/	13,348.4		14,508.6	0%
Бусад богино хугацаат өр төлбөр	4,515,575.1	1%	5,340,546.6	9%
Богино хугацаат өр төлбөрийн дүн	24,317,608.8	71%	35,576,148.1	61%
Урт хугацаат зээл	5,136,406.9	15%	5,639,025.4	10%
Нөөц /өр төлбөр/	-	-	-	-
Хойшлогдсон татварын өр	-	-	3,718.1	0%
Бусад урт хугацаат өр төлбөр	177,481.3	1%	737,888.5	1%
Урт хугацаат өр төлбөрийн дүн	5,313,888.2	16%	6,380,632.0	11%
Өр төлбөрийн нийт дүн	29,631,497.0	87%	41,956,780.1	72%
Өмч	8,513,819.0	25%	9,404,419.1	16%
- хувийн	8,513,819.0	25%	9,404,419.1	16%
Нэмж төлөгдсөн капитал	2,278,232.1	7%	2,278,232.1	4%
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	297,352.1	1%	321,263.9	1%
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	-	-	8.2	0%
Эздийн өмчийн бусад хэсэг	1,776,351.4	5%	2,919,013.1	5%
Хуримтлагдсан ашиг	-8,484,961.7	-25%	1,161,797.6	2%
Эздийн өмчийн дүн	4,380,792.8	13%	16,084,734.0	28%
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	34,012,289.8	100%	58,041,514.1	100%

Хүснэгт 5. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн 2022 оны санхүүгийн тайлан (мянган төгрөг)

Тусгай зөвшөөрөл бүхий үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 47 хуулийн этгээд 100 хувь нэгтгэлд хамрагдсанаас тайлант үеийн үзүүлэлтээр 44 хуулийн этгээд, өмнөх улирлын тайлангийн үзүүлэлтээр 3 хуулийн этгээд хамрагдсан байна.



47

Өмнөх улирлын тайлангийн үзүүлэлтээр

3

Тайлант үеийн үзүүлэлтээр

44

**САНХҮҮГИЙН ТАЙЛАН
2022 ОН**

**НИЙТ
ХӨРӨНГӨ**
58,041,514.1
мянган төгрөг

**ӨР ТӨЛБӨР,
ЭЗДИЙН
ӨМЧИЙН ДҮН**
58,041,514.1
мянган төгрөг

76% Эргэлтийн хөрөнгө

72% Өр төлбөр

24% Эргэлтийн бус хөрөнгө

28% Эздийн өмч

Дурслал 11. Санхүүгийн тайлангийн бүтэц

Нийт хөрөнгө 58,041,514.1 мянган төгрөгт хүрч мөн үеэс 1.7 дахин буюу 24,029,224.3 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.


Нийт өр төлбөр 41,956,780.1 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1.4 дахин буюу 12,325,283.1 мянган төгрөгөөр, эздийн өмчийн дүн өмнөх оноос 3.7 дахин буюу 11,703,941.2 мянган төгрөгөөр өссөн байна.

Нийт хөрөнгийн 76 хувийг эргэлтийн хөрөнгө, 24 хувийг эргэлтийн бус хөрөнгө эзэлж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад эргэлтийн хөрөнгө 1 пунктаар өссөн байна.

Эх үүсвэрийн хувьд өр төлбөр 72 хувь, эздийн өмч 28 хувийг эзэлж байгаа бөгөөд өр төлбөрийн дүн өнгөрсөн оноос 15 пунктаар буурчээ.

ҮЗҮҮЛЭЛТ	2021 он	2022 он	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Эргэлтийн хөрөнгийн дүн	25,522,974.10	44,034,636.10	18,511,662.00	73%
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	8,489,315.70	14,006,878.00	5,517,562.30	65%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	34,012,289.80	58,041,514.10	24,029,224.30	71%
Богино хугацаат өр төлбөрийн дүн	24,317,608.80	35,576,148.10	11,258,539.30	46%
Урт хугацаат өр төлбөрийн дүн	5,313,888.20	6,380,632.00	1,066,743.80	20%
Өр төлбөрийн нийт дүн	29,631,497.00	41,956,780.10	12,325,283.10	42%
Эздийн өмчийн дүн	4,380,792.80	16,084,734.00	11,703,941.20	267%
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	34,012,289.80	58,041,514.10	24,029,224.30	71%

Хүснэгт 6. Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчдийн санхүүгийн тайлангийн ерөнхий үзүүлэлтүүд (мянган төгрөг)




Дүрслэл 12. Хөрөнгийн бүтэц

Эргэлтийн хөрөнгө нийт дүнгээрээ 18,511,662.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, 44,034,636.1 мянган төгрөгт хүрсэн байна. Эргэлтийн хөрөнгийн бүтцийг урьд оны мөн үетэй харьцуулан авч үзвэл мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө 3 пунктаар, бараа материал 6 пунктаар өссөн бол авлага 4 пунктаар буурсан байна.


Эргэлтийн бус хөрөнгө нийт дүнгээрээ 5,517,562.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, 14,006,878.0 мянган төгрөгт хүрсэн байна. Эргэлтийн бус хөрөнгийн 21 хувийг үндсэн хөрөнгө бүрдүүлж байгаа бөгөөд тайлант жилийн эцэст үндсэн хөрөнгийн хэмжээ 12,258,005.2 мянган төгрөгт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 1.6 дахин өсжээ.

Богино хугацаат өр төлбөрийн дүн 35,576,148.1 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.5 дахин буюу 11,258,539.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Урт хугацаат өр төлбөрийн дүн 6,380,632.0 мянган төгрөгт хүрч, урьд оны мөн үеэс 1.2 дахин буюу 1,066,743.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.




Дүрслэл 13. Өр төлбөрийн бүтэц



Дүрслэл 14. Эздийн өмчийн бүтэц

Эздийн өмчийн нийт дүнгийн 16 хувийг хувь нийлүүлсэн хөрөнгө, 4 хувийг нэмж төлөгдсөн капитал, 5 хувийг эздийн өмчийн бусад хэсэг, 2 хувийг хуримтлагдсан ашиг тус тус эзэлж байна.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 47 хуулийн этгээд нь тайлант он буюу 2022 оны байдлаар нийт 75 хувьцаа эзэмшигчийн 9,404,419.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.5 хувь буюу 890,600.1 мянган төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагааг эрхлэх хуулийн этгээдийн тоо нэмэгдсэнтэй холбоотой байна.



Дүрслэл 15. Хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт (мянган төгрөг)


ОРЛОГЫН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

ҮМҮЧЭТХЭАЭ нь тайлант онд 72,298,349.5 мянган төгрөгийн орлого, 58,194,967.6 мянган төгрөгийн зардал, 14,103,373.7 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Тусгай зөвшөөрөлтэй 47 үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч хуулийн этгээдийн ирүүлсэн тайлан мэдээнээс үзэхэд борлуулалтын орлого 5.9, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 6.8, борлуулалт, маркетингийн зардал 3 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Орлогын бүтцийн талаар

Тайлант онд нийт орлого 72,298,349.5 мянган төгрөгт хүрч, урьд оны мөн үеэс 5.8 дахин буюу 59,847,285.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Нийт орлогын 99 хувийг борлуулалтын орлого, 1 хувийг түрээсийн орлого тус тус бүрдүүлж байна. Борлуулалтын орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5.9 дахин буюу 59,456,034.3 мянган төгрөгөөр нэмэгдэж, 71,511,287.6 мянган төгрөгт хүрсэн байна.



Дүрслэл 16. Орлогын бүтэц

№	Үзүүлэлт	2021 он	Орлогод эзлэх хувь	2022 он	Орлогод эзлэх хувь
1	Борлуулалтын орлого (цэвэр)	12,055,253.3	97%	71,511,287.6	99%
2	Түрээсийн орлого	338,632.7	3%	572,192.7	1%
3	Хүүний орлого	-	0%	18,855.2	0%
4	Бусад орлого	57,177.8	0%	84,717.7	0%
5	Үндсэн хөрөнгө данснаасгарз хассаны олз (гарз)	-	0%	6,032.3	0%
6	Бусад ашиг (алдагдал)	-	0%	105,255.8	0%
7	Бусад дэлгэрэнгүй орлого	-	0%	8.2	0%
8	Нийт орлого	12,451,063.8	100%	72,298,349.5	100%

Хүснэгт 7. ҮМҮЧЭТХЭАЭ-дийн орлогын бүтэц (мянган төгрөг)

Зардлын бүтцийн талаар



Тайлант онд нийт зардал 58,194,967.6 мянган төгрөгт хүрч, урьд оны мөн үеэс 3.8 дахин буюу 42,914,791.3 мянган төгрөгөөр өссөн байна. Нийт зардлын бүтцэд борлуулсан бүтээгдэхүүний өртөг 73 хувь, борлуулалт, маркетингийн зардал 10 хувь, ерөнхий ба удирдлагын зардал 10 хувь, татварын зардал 5 хувь, санхүүгийн зардал 2 хувийг тус тус эзэлж байна.

Борлуулсан бүтээгдэхүүний өртөг 42,397,727.2 мянган төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.8 дахин, борлуулалт, маркетингийн зардал 3 дахин өссөн бол ерөнхий ба удирдлагын зардал 0.9 дахин буурсан үзүүлэлттэй байна.

Дүрслэл 17. Зардлын бүтэц

№	Үзүүлэлт	2021 он	Зардалд эзлэх хувь	2022 он	Зардалд эзлэх хувь
1	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	6,180,595.5	40%	42,397,727.2	73%
2	Борлуулалт, маркетингийн зардал	1,843,687.7	12%	5,651,592.0	10%
3	Ерөнхий ба удирдлагын зардал	6,697,382.1	44%	5,975,784.8	10%
4	Санхүүгийн зардал	418,545.4	3%	931,544.4	2%
5	Бусад зардал	29,817.5	0%	240,603.1	0%
6	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	12,300.6	0%	288,817.6	0%
7	Татварын зардал	97,847.5	1%	2,708,898.5	5%
8	Нийт зардал	15,280,176.3	100%	58,194,967.6	100%

Хүснэгт 8. ҮМҮЧЭТХЭАЭ-дийн зардлын бүтэц (мянган төгрөг)

**ТАЙЛАНТ ҮЕИЙН
ЦЭВЭР АШИГ**



14,103,373.7
МЯНГАН ТӨГРӨГ

ДҮГНЭЛТ

1. Салбарын ерөнхий мэдээлэл

Тайлант онд нийт 8 хуулийн этгээд, 29 иргэнд үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгож, 1 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноор 2022 оны жилийн эцсийн байдлаар Хороонд бүртгэлтэй 47 хуулийн этгээд, 465 иргэн зохицуулалтын салбарт үйл ажиллагаа эрхэлж байна. Мөн нэр бүхий 3 хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн. Түүнчлэн Хорооны даргын тушаалаар нийт 5 салбар нээн ажиллуулах зөвшөөрлийг нэр бүхий 2 ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдэд олгосон байна.

Хорооноос үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон 47 хуулийн этгээд, 465 иргэн нь Монгол Улсын 11 аймаг, Улаанбаатар хотын 6 дүүрэгт үйл ажиллагаа эрхэлсэн байна. Үүнээс, 94 иргэн, 1 хуулийн этгээд орон нутагт үйл ажиллагаа эрхэлж буй бол 371 иргэн, 46 хуулийн этгээд нь Улаанбаатар хотын Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул дүүргүүдэд төвлөрсөн байна.

Хороонд бүртгэлтэй үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 70 иргэний 63 хувь нь эрэгтэй, 37 хувь нь эмэгтэй, үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгч 140 иргэний 64 хувь нь эрэгтэй, 36 хувь нь эмэгтэй бол үнэт металл болон үнэт чулуугаар хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 255 иргэний 33 хувь нь эрэгтэй, 67 хувь нь эмэгтэй байна.

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 465 иргэний 0.9 хувийг 18-24 насныхан, 14.4 хувийг 25-34 насныхан, 35 хувийг 35-45 насныхан, 33 хувийг 46-55 насныхан, 16.7 хувийг 55-аас дээш насныхан тус тус эзэлж байна.

ҮМҮЧЭТХЭАЭ үйл ажиллагаа эрхэлж буй 99 иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд газар дээрх хяналт, шалгалт хийж гүйцэтгэснээс 1 хуулийн этгээдийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх арга хэмжээ авч, дээрх төрлийн үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүй эрхэлж буй 2 хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу 10 сая төгрөгийн торгууль оногдуулж, үйл ажиллагааг зогсоосон.

ҮМҮЧЭТХЭАЭ-дэд эрх олгох сургалтыг хүртээмжтэй болгох зорилгоор цахим сургалтыг нэвтрүүлсэн.

ҮМҮЧЭТХЭАЭ-ийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчлан таниулах, тусгай зөвшөөрлийн талаарх ойлголтыг иргэд, олон нийтэд хүргэх зорилгоор мэргэжлийн холбоотой хамтран “MONGOLIAN JEWELLERY & METAL EXPO-2022” арга хэмжээг зохион байгуулж, салбарын зохицуулалтыг сайжруулах зөвлөмжийг боловсруулсан.

2. Борлуулалтын тойм

ҮМҮЧЭТХЭАЭ-ийн салбарын нэгтгэлд тайлант үеийн үзүүлэлтээр 44, өмнөх улирлын тайлангийн үзүүлэлтээр 3 хуулийн этгээд, нийт 47 хуулийн этгээд 100 хувийн ирцтэйгээр хамрагдлаа.

Үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь тайлант хугацаанд 8.5 тонн алтыг 699,391,516.9 мянган төгрөгөөр худалдан авч, 8.3 тонн алтыг 670,518,154.9 мянган төгрөгөөр худалдан борлуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал худалдан авсан алтны хэмжээ 115,780,015.7 мянган төгрөгөөр буюу 20 хувиар өссөн бол худалдсан алтны хэмжээ 23,683,110.0 мянган төгрөгөөр буюу 3.4 хувиар буурсан байна.

Тайлант хугацаанд үнэт металл, үнэт чулууны арилжаа эрхлэгчид нь нийт 182.1 кг мөнгийг 707,357.3 мянган төгрөгөөр худалдан авч, 92.8 кг мөнгийг 284,162.6 мянган төгрөгөөр худалдан борлуулсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад худалдаж авсан мөнгөний хэмжээ 2.5 дахин буюу 426,509.1 мянган төгрөгөөр, худалдсан мөнгөний хэмжээ 1.2 дахин буюу 40,836.1 мянган төгрөгөөр тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Мөн 2022 онд 14.7 тэрбум төгрөгийн үнэт эдлэлийг худалдан борлуулсан байна.

3. ХНХ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүний талаар

Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч 47 хуулийн этгээд нь 2022 оны байдлаар нийт 75 хувьцаа эзэмшигчийн 9,404,419.1 мянган төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаа эрхэлсэн бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 890,600.1 мянган төгрөг буюу 10.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

4. Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Тайлант онд тусгай зөвшөөрөлтэй 47 хуулийн этгээдийн нийт хөрөнгө 58,041,514.1 мянган төгрөгт хүрч урьд оны мөн үетэй харьцуулахад 1.7 дахин буюу 24,029,224.3 мянган төгрөгөөр өссөн бөгөөд энэхүү өсөлтөд мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө болон бараа материалын өсөлт нөлөөлсөн байна. Тодруулбал, тайлант хугацаанд мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө 3 пункт, бараа материал 6 пунктаар тус тус өссөн байна.


Тайлант хугацаанд нийт өр төлбөр 41,956,780.1 мянган төгрөгт хүрч, урьд оны мөн үетэй харьцуулбал 1.4 дахин буюу 12,325,283.1 мянган төгрөгөөр, эздийн өмчийн дүн урьд оноос 3.7 дахин буюу 11,703,941.2 мянган төгрөгөөр тус тус өссөн байна. Энэ нь тайлант онд хуримтлагдсан ашиг өмнөх оны мөн үеэс 9,646,759.3 мянган төгрөгөөр өсөж, 161,797.6 мянган төгрөгт хүрсэн байна.

5. Орлого, зардал, ашигт ажиллагаа

ҮМҮЧЭТХЭАЭ нь тайлант онд 72,298,349.5 мянган төгрөгийн орлого, 58,194,967.6 мянган төгрөгийн зардал, 14,103,373.7 мянган төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна. Тусгай зөвшөөрөлтэй 47 ҮМҮЧЭТХЭАЭ хуулийн этгээдийн ирүүлсэн тайлан мэдээнээс үзэхэд тайлант хугацааны борлуулалтын орлого 5.9 дахин, түрээсийн орлого 1.7 дахин өссөн бол нөгөө талаас борлуулсан бүтээгдэхүүний өртөг 6.8 дахин, борлуулалт, маркетингийн зардал 3 дахин, санхүүгийн зардал 2.2 дахин, татварын зардал 27.7 дахин өссөн байна.

 САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

 Зохицуулалтын салбарууд:

 Үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч

 Үл хөдлөх хөрөнгө зуучлал

МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ

WWW.FRC.MN



СОШИАЛ МЕДИА



/САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

ЛАВЛАХ УТАС

 51 262607

 51 262604


 51 261881

ЦАХИМ ШУУДАН

 Dpms@frc.mn

 Realestate@frc.mn

Үл хөдлөх хөрөнгө зуучлал, үнэт эдлэлийн
зохицуулалтын газар



УЛААНБААТАР ХОТ

2022 он